

ТООН КОНТЕНТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Харилцаа холбооны тухай хуулийн 8.1, 9.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-д заасныг тус тус үндэслэн харилцаа холбооны сүлжээгээр контентын үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг баримтлана.
- 1.2 Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) болон харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, контентын агрегатор, контент нийлүүлэгч, вэб сайтын үйлчилгээ эрхлэгч, контент хостингийн үйлчилгээ эрхлэгч нар контентын үйлчилгээтэй холбогдсон харилцаанд энэхүү зохицуулалтыг дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 “Контент” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг тоон хэлбэрт хувиргасан бүтээгдэхүүн; Энэхүү контентид дараахь зүйлс хамаарахгүй. Үүнд:
 - цахим шуудан, балк болон спам захидал;
 - хувь хүмүүсийн хоорондын харилцаа (Жишээ нь: телефон яриа, факс, Айпи телефон яриа гэх мэт)
- 2.2 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч (цаашид “үйлчилгээ эрхлэгч” гэх) нь контентыг хүргэгч суваг ба контентын үйлчилгээг өөрийн хэрэглэгчдэд дамжуулан хүргэх боломжийг хангасан сүлжээ бүхий эсхүл бусдын сүлжээ ашиглан дээрхи боломжийг хангасан, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд; Үүнд дараахь үйлчилгээ эрхлэгчид хамаарна:
 - үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч;
 - интернэтийн үйлчилгээ эрхлэгч;
 - Айпи ТВ-ийн үйлчилгээ эрхлэгч;
 - Мобайл ТВ-ийн үйлчилгээ эрхлэгч ;

- тоон контентыг дамжуулах бололцоог олгож байгаа бусад үйлчилгээ эрхлэгчид.

- 2.3 “Контентын агрегатор” (aggregator) гэж контент нийлүүлэгчийн бүтээгдэхүүнийг үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулахын тулд өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийг ашиглан хувиргах, тохируулах, борлуулах зорилготой контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд;
- 2.4 Контент нийлүүлэгч гэж бүтээгдэхүүний зохиогчийн эрхийг эзэмшигч, эсхүл контентыг хөгжүүлэн контентын агрегаторд нийлүүлдэг хувь хүн, хуулийн этгээд; Үүнд дуучид, хөгжимчид, зохиолчид гэх мэт мэдээллээр хангагчид, болон програм хангамж ашиглан контентыг бий болгогчид;
- 2.5 Контент хостингийн үйлчилгээ эрхлэгч гэж өөрийн сервер дээр вэб болон бүх төрлийн цахим өгөгдлийг байршуулж, тэдгээрт хэрэглэгчид харилцаа холбооны сүлжээ ашиглан хандах боломжийг олгодог үйлчлэгч;
- 2.6 Вэб сайтын үйлчилгээ эрхлэгч гэж харилцаа холбооны сүлжээ ашиглан олон нийтэд мэдээ, мэдээлэл болон бусад бүх төрлийн контентыг хүргэдэг иргэн болон хуулийн этгээд.

Гурав. Тусгай зөвшөөрөл

- 3.1 Контентын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлага, холбогдох журмын дагуу олгоно.
- 3.2 Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ил тод нээлттэй байлгана.
- 3.3 Тусгай зөвшөөрлийг олгохдоо дараахь зарчмыг баримтлана:
 - 3.3.1 тухайн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаанд үндэслэх;
 - 3.3.2 аливаа нөлөөллөөс үл хамаарах, ил тод, шударга байх;
 - 3.3.3 ялгаваргүй арга замаар олгох.
- 3.4 Контентын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг дараахь төрлөөр олгоно:

3.4.1 контент хостингийн үйлчилгээ;

3.4.2 контент агрегатор.

- Онлайн (онлайн болон оффлайн хэлбэрийн аль ч төрлийн тоон контентын үйл ажиллагаа явуулах боломжтой этгээд байна)
- Мобайл (үүрэн холбооны хэрэглэгчийн гар утасны функц, үйлдлийн системд тохируулан бүтээсэн тоон контентын үйл ажиллагаа явуулах боломжтой этгээд байна)

3.5 Вэб сайтын үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийн хандалтын дундаж нь нэг сарын хугацаанд өдөрт гурван мянгаас давсан тохиолдолд Зохицуулах хороонд бүртгүүлнэ.

3.6 Тоон контентыг ашиглан арилжааны зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа вэб сайтыг контент агрегатор гэж үзнэ.

3.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлага, үндсэн үйл ажиллагаатай холбоотой харилцаагаа бусдад шилжүүлэхийг хориглоно.

Дөрөв. Контентын агуулгад тавигдах шаардлага

Дор дурдсан болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн контент бүтээх, түгээхийг хориглоно:

4.1 Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн дагуу эротик төрлийн контентыг агуулсан, садар самууныг илэрхийлсэн;

4.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасан зүйлсийг сурталчилсан, илэрхийлсэн;

4.3 Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн дагуу үндэсний эв нэгдлийг бусниулах чиглэлээр сурталчилгаа явуулсан;

4.4 Эрүүгийн хуулийн 178³ дугаар зүйлийн дагуу терроризмийг сурталчилсан;

4.5 Эрүүгийн хуулийн 179 дугаар зүйлд заасан нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан;

4.6 Эрүүгийн хуулийн 144 дугаар зүйлийн дагуу шашны харгис үзэл номлолыг сурталчилсан;

- 4.7 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1.2-д заасан зүйлсийг илэрхийлсэн;
- 4.8 Зар сурталчилгааны тухай хуулийн 6-р зүйлийн 6.5.5, 6.5.7, 6.5.8 болон 7-р зүйл, 13.4, 13.6, 13.8, 14-р зүйл, 16-р зүйл, 17.2-д заасан зар сурталчилгаа агуулсан;
- 4.9 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12.1, 12.2, 20.1, 21.1, 22.1, 25.1 –д заасныг зөрчиж, зохиогч эсхүл эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг нь ашигласан;
- 4.10 Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан согтууруулах ундаа сурталчилсан;
- 4.11 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.6-ийн дагуу хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлсэн;
- 4.12 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5-д заасан зүйлсийг илэрхийлсэн;
- 4.13 Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2.3-ийн дагуу эротик төрлийн контентыг агуулсан.

Тав. Үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлага

Үйлчилгээ эрхлэгчид дараахь нөхцөл шаардлага тавигдана:

- 5.1 Үйлчилгээ эрхлэгч нь контентын агрегаторт тавих нийтлэг нөхцөл шаардлагаа ялгаварлахгүй, ижил нөхцөл бололцоогоор хангах зарчмыг баримтлан тогтоож, олон нийтэд ил тод байлгана. Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хороогоор хянуулна.
- 5.2 Контентын чанарыг бууруулахгүй, агуулгыг өөрчлөхгүйгээр дамжуулах боломжийг бүрдүүлсэн байна.
- 5.3 Интернэтийн үйлчилгээ эрхлэгчээс бусад үйлчилгээ эрхлэгч нь өөрөө контентын агрегатор байж болохгүй.
- 5.4 Шинээр хэрэглэгч бүртгэхдээ хэрэглэгчийн хүсэлтээр энэхүү нөхцөл шаардлагын 4.11-4.13 дугаар зүйлд заасан контентид нэвтрэх, үзэх, татаж авах, хандалтыг хязгаарлах боломжийг бүрдүүлнэ.

- 5.5 Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч нь агрегаторыг өөрийн төлбөр тооцооны системтэй байх боломжийг нээлттэй байлгана.
- 5.6 Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчийн контентын үйлчилгээнээс авах орлого нь хэрэв контентын үйлчилгээнд өөрийн төлбөр тооцооны системийг ашиглаж байвал 20 хувиас, бусад тохиолдолд 10 хувиас хэтрэхгүй байна (хүснэгтээр харуулав).

Хүснэгт 1: Контентын үйлчилгээний орлого хувиарлалт

Оролцогч талууд	Үйлчилгээ эрхлэгчийн төлбөрийн системийг ашиглаж буй бол	Бусад тохиолдолд
Үйлчилгээ эрхлэгч	< 20%	< 10%
Контентын агрегатор	> 80%	> 90%

- 5.7 Төрөөс баримтлах чиглэлийн дагуу интернэт хаягийн дараагийн (IPv6) хувилбарт шилжинэ.
- 5.8 Зохицуулах хорооноос зарласан зөрчилтэй интернэт хаягийг (IP address) өөрийн серверээр дамжуулан интернэтэд холбохгүй байх үүргийг интернэтийн үйлчилгээ эрхлэгч хүлээнэ.
- 5.9 Өөрийн үндсэн үйлчилгээ болон контентын үйлчилгээний талаархи ялгаа заагийг тодорхой тусгасан заавар зөвлөмж, үнэ тарифын мэдээллээр хэрэглэгчдийг хангана.
- 5.10 Контентын үйлчилгээний үнийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэн байх бөгөөд төлбөр тооцоог хэрэглэгч өөрийн билл дээр контентын агрегатор тус бүрээр нь хянах боломжийг олгоно.
- 5.11 Зохицуулах хороонд контентын үйлчилгээтэй холбоотой шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

Зургаа. Контентын агрегаторт тавигдах нөхцөл шаардлага

Контентын агрегаторт дараахь нөхцөл шаардлага тавигдана:

- 6.1 Контент агрегатор нь контент нийлүүлэгчид тавих нийтлэг нөхцөл шаардлагаа ялгаварлахгүй, ижил нөхцөл бололцоогоор хангах зарчмыг баримтлан тогтоож, олон нийтэд ил тод байлгана. Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хороогоор хянуулна.

- 6.2 Контентын үйлчилгээнээс авах орлого нь 50 хувиас доошгүй байна.
- 6.3 Хэрэглэгчид хүргэх контент нь энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг зөрчсөн эсэхэд хяналт тавих үүрэг хүлээх бөгөөд чанарын шаардлага хангасан контентээр үйлчлнэ.
- 6.4 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг зөрчсөн тохиолдолд зөрчлийг гарсан даруйд нь таслан зогсоох техникийн боломж, нөхцлийг хангасан байна.
- 6.5 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4.11-4.13-д заасан контентээр үйлчлэхдээ хэрэглэгчидэд 18-аас дээш насныханд зориулсныг урьдчилан сануулсан байх ба хэрэглэгчийн хүсэлтээр контентын үйлчилгээнд тодорхой хязгаартайгаар хандалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.6 Холбоо барих мэдээлэл, хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах төлөөлөгчийн газрын хаяг болон утасны дугаар зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана.
- 6.7 Контентын үйлчилгээний үнийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэн байх ба үйлчилгээ эрхлэгч нь төлбөр тооцооны зарчим, төлбөр тооцоог хэрэглэгч хянах боломжийг олгоно.
- 6.8 Зохицуулах хороонд контентын үйлчилгээтэй холбоотой шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

Долоо. Вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид тавигдах нөхцөл шаардлага

Вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид дараахь нөхцөл шаардлага тавигдана:

- 7.1 Хэрэглэгчийн хандалтын дундаж нь нэг сарын хугацаанд өдөрт гурван мянгаас давсан тохиолдолд Зохицуулах хороонд бүртгүүлнэ.
- 7.2 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгоно.
- 7.3 Хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараахь зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. Үүнд:
 - 7.3.1 Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программыг заавал ашиглах;

- 7.3.2 Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээг ашиглахыг сануулсан нөхцөл шаардлагыг зөвшөөрсөн хэрэглэгчийг контент үүсгэх боломжоор хангах;
- 7.3.3 Хэрэглэгч аль нэг өөр хэрэглэгчийн үүсгэсэн контентыг хууль бус, нийтийн ёс зүйд сөрөг нөлөөтэй гэж үзвэл саналаа илэрхийлэх, саналын тооноос хамааран тухайн контентыг арилгах боломжийг бүрдүүлэх;
- 7.3.4 Хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах;
- 7.3.5 Хэрэглэгчийн үүсгэсэн контентыг 4 дүгээр бүлгийн заалтыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд түүнийг арилгах;
- 7.4 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр бүлгийг зөрчсөн контентыг үүсгэсэн хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) вэб сайтын үйлчилгээ эрхлэгч эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн этгээд нь Зохицуулах хороонд нотлох баримтын хамт ирүүлж болно.
- 7.5 Вэб сайтын үйлчилгээ эрхлэгч нь энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4.11-4.13-д заасан контентээр үйлчлэхдээ хэрэглэгчидэд 18-аас дээш насныханд зориулсныг урьдчилан сануулна.

Найм. Контент хостингийн үйлчилгээ эрхлэгчид тавигдах нөхцөл шаардлага

Контент хостингийн үйлчилгээ эрхлэгчид дараахь нөхцөл шаардлага тавигдана:

- 8.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр бүлгийг зөрчсөн контентыг байршуулахгүй байна.
- 8.2 Зохицуулах хороонд контентын үйлчилгээтэй холбоотой шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.
- 8.3 Интернэт хаягийн дараагийн (IPv6) хувилбарт шилжих төрөөс баримтлах төлөвлөгөөний дагуу бэлтгэж шилжилтийг хийнэ.

Ес. Хяналт

- 9.1 Зохицуулах хороо энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлд зааснаас бусад заалтуудад хамаарах хяналтыг хэрэгжүүлнэ.

9.2 Зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ дараахь арга хэрэгслийг ашиглана:

9.2.1 Хэрэглэгч, байгууллагын өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийх;

9.2.2 Контентын агрегатор, хостингийн болон вэб сайтын үйлчилгээ эрхлэгчээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах;

9.3 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлд дурдсан агуулгын хяналтыг холбогдох хуульд заасан эрх бүхий хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

9.4 Зохицуулах хороо вэб сайтын үйлчилгээ эрхлэгч эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн этгээдээс ирүүлсэн зөрчилтэй интернэт хаягийг (IP address) бүртгэж зарлан холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

Арав. Гомдол маргаан шийдвэрлэх

10.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өргөдөл, гомдол хүлээж авч, шийдвэрлэх өөрийн журамтай байх ба өргөдөл, гомдол хүлээж авах хаяг, утас зэрэг мэдээллийг ил тод мэдээлнэ.

10.2 Гомдол, маргаантай асуудлыг маргалдагч талууд шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шаардлагатай бол Зохицуулах хороонд хандаж болно.

10.3 Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

Арван нэг. Хариуцлага

11.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу дараахь шаардлагатай арга хэмжээг авна:

11.1.1 зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;

11.1.2 захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх;

11.1.3 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;

- 11.1.4 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;
- 11.1.5 тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох.
- 11.2 Зохицуулах хороо нь хэрэглэгч болон холбогдох байгууллагын гомдол, өргөдөл дээр үндэслэн холбогдох хууль хяналтын байгууллага болон контентын агрегатор, вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.
- 11.3 Зохицуулах хороо холбогдох хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг доор заасан арга хэмжээ авахыг контентын агрегатор, вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэнэ.
- 11.3.1 Мэдэгдэл хүлээн авснаас 24 хүртэлх цагийн дотор уг зөрчлийг арилгах арга хэмжээ авч хариуг мэдэгдэх;
- 11.4 Хэрэв заасан хугацаанд зөрчлийг арилгахгүй бол уг контентын агрегатор болон вэб сайтын үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээг зөрчил арилтал түр зогсоох тухай мэдэгдлийг Зохицуулах хорооноос үйлчилгээ эрхлэгчид өгнө.
- 11.5 Үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хорооноос мэдэгдэл өгсөн тохиолдолд доор заасан арга хэмжээг 24 хүртэлх цагийн дотор авна.
- 11.5.1 Үйл ажиллагааг нь түр зогсоох тухай контентын агрегатор болон вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэх;
- 11.5.2 Контентын агрегатор болон вэб сайтын үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээг зөрчил арилтал зогсоож, хариуг Зохицуулах хороонд мэдэгдэх;
- 11.6 Дээрхи зөрчил давтагдсан тохиолдолд Зохицуулах хороо нь энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 11.1.3 - 11.1.5–д заасан арга хэмжээг авна.
- 11.7 Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан шийдвэрийг Зохицуулах хороо тухай бүр холбогдох талууд болон олон нийтэд ил тод мэдээлнэ.
- 11.8 Зохицуулах хороо нь контент агрегатор, вэб сайтын үйлчилгээ эрхлэгч болон үйлчилгээ эрхлэгчээс авсан бизнесийн болон хэрэглэгчдийн мэдээллийг зөвхөн зохицуулалтын үйл ажиллагаанд ашиглана.